

ОЙРХИ ДОРНОДЫН ОРОН СУДЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

*Ж.Жаргал**

Газар зүй, байгалийн баялаг

Ойрхи дорнод (Middle east) нь Европ, Ази, Африк тивийн уулзварт оршдог. Энэ бүс нутаг арабын ертөнц (Arab world) гэсэн нэрээр олонд илүү танигджээ. Энэхүү нэрийг өрнөдийн хэвлэл мэдээлэл өгсөн бөгөөд Азийн, эсвэл Африкийн ертөнц гэж бид хэзээ ч ярьдаггүй.

Ойрхи дорнодод Мороккоогоос Иран хүртлэх газар нутгийг хамруулан ойлгодог. Дотроо хэд хэдэн мужуудад хуваагдана. Хойд Африкийн хэсэгт (Maghreb) Морокко, Алжир, Тунис, Ливи, Судан, Египет, Ойрхи дорнодын (Near east) хэсэгт Израйль, Ливан, Иордан, Сири, Ирак, Саудын Араб, Йемен, персийн булангийн жижиг орнууд орно. Хойд хэсэгт (Northern belt) Турк, Иран ордог.

Хойд Африкийн бүс нутаг нь Африкийн бусад орнуудаас Сахарын элсэн цөлөөр зааглагддаг. Ойрхи дорнод нь Хойд Африкаас улаан тэнгисээр тусгаарлагддаг. Саудын Арабын газар зүйн онцлог байдал нь түүнийг дэлхий ертөнц, бүр арабын ертөнцөөс тусгаарладаг. Саудын Араб бүс нутгийн бусад орнуудтай харьцуулахад хэзээ ч бүрэн колончлогдож, европын нөлөөнд орж байгаагүй.

Хар алт буюу газрын тос нь Арабын ертөнцийн дүр төрхийг өөрчилсөн гол баялаг юм. Дэлхийн газрын тосны нөөцийн талаас илүү хувь нь ойрхи дорнодын бүс нутагт байдаг бөгөөд Саудын Араб дангаараа 170 тэрбум баррель нефтийн нөөцтэй. Ойрхи дорнод баруун европын нефтийн хэрэглээний 40%, японы 90% -ийг хангадаг.

Ойрхи дорнод нь геостратегийн чухал ач холбогдолтой бүс нутаг юм. Туркийн хоолой, Суэцийн суваг, Хормузын хоолой зэрэг олон улсын ач холбогдолтой газруудыг дурдвал зохино. Дэлхийн II дайны үед Герман, Итали, хүйтэн дайны үед ЗХУ болон АНУ тэргүүтэй орнууд өөрийн хяналт нөлөөгөө энэ бүс нутагт нэмэгдүүлэхийг хичээж байв. ЗХУ 1950-1960 онд Алжир, Египет, Сиритэй хамтран ажиллаж эдгээр оронд байр сууриа бэхжүүлж чадсан ч 1970-аад оноос нөлөөгөө огцом алдсан билээ.

Шашин

Ойрхи дорнод нь гурван том монотеист шашны өлгий нутаг юм. Иудайн, христ, ислам гэсэн гурван том шашин дэлхий даяар тархсан боловч энэ бүс нутаг тэдгээрийн төв нь хэвээр үлджээ.

Иудайн болон христийн шашин нь исламыг бодвол ойрхи дорнодод илүү эрт үүсчээ. Мусулманчуудтай нэгэн адил еврейчүүд болон христийн шашинтнууд Иерусалимыг ариунаас ариун газар,

* Ж.Жаргал - МУИС-ийн магистрант

Палестиныг ариун нутаг гэж үздэг. Иудайн болон христийн шашин нь нэг эх үүсвэртэй боловч хоорондоо олон зүйлээрээ ялгардаг. Тухайлбал ёс заншил, шашны баяр, мөргөл хийдэг газрууд нь өөр өөр юм.

Арабын ертөнцийн нийт хүн амын 90% нь ислам шашинтан бөгөөд үлдсэн 10% нь иудайн болон христийн шашинтан. Түүхийн үүднээс авч үзвэл христийн шашинтнууд мусулманчуудтай хамгийн их сөргөлдөж ирсэн бөгөөд мусулманчууд болон еврей нар харьцангуй бага зөрчилдөж байв. Мусулманчууд Аллах бурхан Мухаммадаас өмнө Абрахам, Мосей, Иусус гэсэн зөнчдөөр дамжуулж өөрийгөө мэдүүлсэн гэж үздэг.

Ислам шашин нь сунни болон шийт гэсэн хоёр урсгалтай. Нийт мусулманчуудын 90% нь сунни (sunni) үлдсэн хэсэг нь шийтүүд (shiite) юм. Ихэнхи шийтүүд иранчууд болно.

Жихад гэсэн нэр томъёог өнөө үед их хэрэглэх болсон байна. Энэ үг нь ариун дайн, ариун тэмцэл гэсэн утгатай бөгөөд энгийнээр ойлговол бурхны хүсэл зоригийг биелүүлэхийн төлөө хүчин зүтгэх гэсэн үг юм. Жихад нь дотоодын болон гадаадын дайсны эсрэг чиглэгдсэн байж болдог. Тухайлбал Египетийн ерөнхийлөгч Анвар ал Садатыг хөнөөсөн хэрэг явдал үүний жишээ болж орно.

Ойрхи дорнодын түүх

Арабын ертөнцийн түүхийн алтан үе нь Мухаммад исламыг үндэслэсэн VII зуун юм. Мухаммадыг залгамжлагч халифууд одоогийн Ирак, Иран, Сири, Египет, Кипр, Хойд Африк, Испанийг эзлэж тухайн үедээ хамгийн хүчирхэг эзэнт гүрнийг байгуулж чадсан байна. Энэ үед Арабууд хөгжлийн өндөр түвшинд хүрч, утга зохиол, философи, түүх, урлаг, шинжлэх ухааны салбарт үнэтэй хувь нэмэр оруулж байлаа. Арабуудын байгуулсан эзэнт улс IX зуунаас эхлэн задарсаар сүүлдээ бие даасан хэд хэдэн улс болон хуваагдсан юм.

Дэлхийн I дайнаас өмнөх Ойрхи дорнодын түүхэнд Оттоманы эзэнт гүрэн, Европын колончлол онцгой байр суурь эзлэдэг. XV зууны сүүлчээс Туркчууд I Сулейманы (1520-1566) удирдлаган дор Балканы хойг, Армени, Ирак, Сири, Египетийг эзлэн авсан байна. Оттоманы эзэнт гүрэн олон улсын ач холбогдолтой боомт хотууд, худалдааны зангилаа замуудыг хянаж байлаа.

XIX зууны хоёрдугаар хагаст Европын гол гүрнүүд Африк, Азийг хуваан эзлээд байсан бол Ойрхи дорнодод тэдний гар хүрээгүй байжээ. Франц, Их Британи, Орос гүрэн бол бүс нутагт хяналтаа тогтоохын төлөө энэ үеэс эхлэн тэмцэж эхлэсэн байна. Улмаар Франц нь Алжир (1830), Тунис (1883), Морокког (1906-1912) эзлэсэн бол Их Британичууд Египетийг, Итали Ливиг өөрийн эзэмшилд оруулж чаджээ. Оросууд Ираныг эзлэхийг хичээж байсан ч Их Британи Ираныг тусгаар улс байлгахыг зорьж, Оросын түрэмгийллээс хамгаалж

чадсан байна. Ираныг Их Британи хамгаалсан шалтгаан нь Орос гүрнээс Энэтхэгийг заагласан тусгаар улс хэрэгтэй байсанд оршино.

Ойрхи дорнодын уламжлалт хаант засаглалтай, исламын хуулийг чанд баримталсан улс орнууд дотроос хамгийн түрүүнд Египет Гамал Абдел Насерын (1954-1970) үед төр шашин хоёрыг зааглаж, улс төрийн амьдрал дахь исламын онцгой үүргийг халжээ. Сири, Ирак, Алжир, Ливи улс Египетийн загварыг дагасан бол Йордан, Морокко, персийн булангийн орнууд өөрийн түүхэн хөгжил, иргэншлийнхээ уламжлалт замаар хэвээр замнажээ.

Ираны шах Мухаммад Реза Пахлави (1941-1979) Өрнөдөөс (ялангуяа АНУ-аас) асар их хэмжээний цэрэг, эдийн засгийн тусламж авч Ираны нийгмийг барууны хэв загварын дагуу шинэчлэхийг оролдсон боловч бүтэлгүйтсэн билээ. 1979 онд Аятолла Рулах Хомейниг хорьсон явдал улс орныг хамарсан үймээн дэгдэхэд хүргэж Шах улс орноо орхин гарахаас өөр аргагүй байдалд оржээ. Шахыг унасаны дараа Иран шашин төр нийлсэн теократ улс болж хувирсан байна. Шашны удирдагчид төрийн үйл ажиллагааг чиглүүлж, исламын хууль төрийн хууль болсон юм. Хомейнигийн засаглалын үед олон мянган сэхээтэн, төрийн хуучин түшмэд, цэргийн дарга нар, улс төрчид баривчлагдан хоригдож, зарим нь цаазлагдсан байна. 1980-аад оны турш Иран улс төр, эдийн засгийн хувьд тогтворгүй байлаа. Энэ бүхний хажуугаар Ираны хувьсгалын нөлөөнөөс айсан Ирак Иран руу довтолсон байна. Ирактэй хийсэн долоон жилийн дайнд эдийн засаг нь сүйрч, хагас сая хүнээ алдсан бөгөөд ер эл дайнд ялагч тал байсангүй, хоёр орон хоёулаа ихээхэн хохирол амсчээ.

Израиль

Израиль улс 1948 онд Палестины газар нутаг дээр байгуулагдсан бөгөөд үүнээс өмнө еврей нар өөрийн гэсэн газар нутаг, төр улсгүй байлаа. Тэд МЭӨ 70 онд Ромын эзэнт улсын эсрэг бослого дэгдээсний улмаас нутгаасаа хөөгдсөнөөс хойш өөрийн улсыг байгуулах мөрөөдөлтэйгөөр амьдарч иржээ. XIX зуунд Европ болон Оросын еврейчүүд дарамт шахалтын улмаас 1882-1914 оны хооронд АНУ руу хэдэн саяараа цагаачлан гарсан байна. Энэ үед олон еврейчүүд тусгаар улс байгуулах тухай үзэл бодлоо илэрхийлж байв. Оросоос Их Британи руу цагаачлан гарсан Чайт Вейзманы шинжлэх ухааны нээлт холбоотны цэрэг дайны үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулсан бөгөөд энэ нь түүнийг Их Британий улс төрийн элит хүрээнд ороход нь нэмэр болжээ. Тэрбээр энэ холбоогоо ашиглан Их Британий засгийн газраас еврейчүүдийг Палестин дахь төрөлх нутаг руугаа буцахад нь туслах амлалтыг авч чадсан байна.

Дэлхийн I дайны дараа Их Британи Палестиныг засан тохинуулах эрхтэй болж, еврейчүүдэд өгсөн амлалтаа биелүүлж эхэлжээ. Дэлхийн хоёр дайны хооронд еврейчүүд үй олноороо Палестин руу нүүсэн байна. Еврейчүүд Палестинд өөрийн гэртээ байгаа юм шиг санаж байсан бол Палестины арабууд тэднийг харийн хүмүүсийн адил таагүй хүлээн авчээ.

Палестины арабууд бол онцгой ард түмэн бөгөөд тэд Ойрхи дорнод дахь арабуудын доторхи хамгийн өндөр боловсролтой, ухаантай хүмүүс гэж үнэлэгддэг. Бусад арабуудыг бодвол хуучинсаг үзэлгүй, шашны хуулийг ягштал баримталдаггүй ажээ. Барууны хэв загварын хувцас өмсөж, англиар чөлөөтэй ярьсгаадаг. Тэд Иорданд сонин эрхлэж, Ливанд банк ажиллуулж, гадаадын олон оронд өндөр цалинтай ажил хийж, АНУ, баруун европын тэргүүлэх их сургуулиудад багшилдаг.

Палестинчууд 1930-аад оноос эхлэн еврейчүүд рүү халдаж эхэлсэн бол 1940-өөд оноос еврейн зэвсэгт бүлэглэлүүд тэдэнд террорист хариу цохилт өгөх болсон байна. Эдгээр бүлгийн гишүүд дотор Израйлийн ирээдүйн ерөнхий сайд Меначем Бегин, Ятцах Шамир нар байлаа.

Британчууд хоёр талын аль алинд нь ашигтай шийдлийг олж чадахгүй байв. Дэлхийн II дайны дараа еврейчүүдийн Палестин руу хөвөрсөн цуваа улам ихсэж, хяналтнаас гарсан байна. Их Британи НҮБ-д Палестины газар нутаг дээр Араб болон Еврейн улс байгуулж Иерусалимыг олон улсын хот болгох санал оруулсан ч түүнийг арабууд эсэргүүцжээ. Улмаар Араб-Израйлийн нэгдүгээр дайн эхэлж 9 сар үргэлжилсэн юм. Дайны улмаас Палестины арабуудын ихэнх нь нутгаасаа дүрвэн гарч, үлдсэн 300000 хүн Израйльд хоёрдугаар ангиллын иргэд болж хоцорчээ.

Арабын орнууд Израйлийн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан юм. Энэ хүнд үед Израйлийг Давид Бен Гурион удирдаж байв. Тэрбээр ерөнхий сайд, батлан хамгаалахын сайдын үүргийг давхар үүрч байлаа. Израйль 1956 онд Египеттэй, 1967 онд Египет, Сири, Иордан, Ливантай, 1973 онд Иом Киппурт дахин Египеттэй, 1983 онд Ливантай, 1989-1991 онд Палестинтай, 2000 онд дахин Палестинтай дайтсан юм. Эдгээр дайнд Израйль илт давуу ялалт байгуулж байлаа.

Израйлийн “буцаж ирэх тухай” хууль онцгой юм. Энэхүү хууль нь еврейчүүдийг Израйль руу хүссэн үедээ эргэн ирэх эрхээр хангадаг бөгөөд хоёр улсын иргэний харъяалалтай байхыг зөвшөөрдөг.

Израйлийн плюралист улс төрийн систем ойрхи дорнодод чухал нөлөө үзүүлдэг. Израйльд бичмэл хууль байдаггүй. Израйлийн парламентыг Кнессет гэх бөгөөд 120 гишүүнтэй, 4 жилийн хугацаагаар сонгогдог. Кнессетэд олонхи болсон нам, эвсэл засгийн газраа байгуулдаг. Израйль нь ёслолын ерөнхийлөгчтэй.

Израиль нь олон намын системтэй. Израйльд ихэнхдээ эвслийн засгийн газар байгуулагддаг бөгөөд олон жижиг намууд улс төрд ихээхэн нөлөөтэй. Том намууд тэдний дэмжлэгтэйгээр засгийн газраа байгуулдаг. Зүүн төвийг сахисан хөдөлмөрийн нам, баруун төвийг сахисан Ликуд нам бол Израйлийн хамгийн том гол хоёр нам юм. Хөдөлмөрийн намыг энх тайвныг эрхэмлэгч нам гэж заримдаа нэрлэдэг. Харин Ликуд нам нь арабуудтай харилцах харилцаанд хатуу байр суурийг баримталдаг. Энэ хоёр намын аль нэг нь парламентэд олонхи болсон ч бусад жижиг намуудтай эвсэхээс өөр аргагүй байдалд ихэвчлэн ордог.

Израиль улс байгуулагдсан цагаас хойш олон хүнд бэрх үеүүдийг туулж иржээ. Олон удаагийн дайн, 1980 оныг бүхэлд нь хамарсан эдийн засгийн хямрал улс орныг хүнд байдалд оруулж байлаа. 1980-1984 онд инфляци 100%, 1985 онд 800% хүртэл өссөн бөгөөд онц байдал зарлахад хүргэж байв. 1988-1991 онд хуучин ЗХУ-аас хагас сая шахам еврей иргэд цагаачлан ирсэн нь хүн амын тоог эрс өсгөж, тэр чинээгээр эдийн засагт дарамт учруулсан байна. Гэвч 1990 оны эцэс гэхэд Израйлийн иргэд арабын ертөнцдөө хамгийн хангалуун амьдралтайд тооцогдох болж нэг хүнд ноогдох ДНБ нь АНУ, Японтой зэрэгцэж ирсэн байна.

Египет

Египетийн нутаг дэвсгэрийн 96% нь элсэн цөл юм. Египетийн 75 сая иргэн Нил мөрний дагуух сав нутагт амьдардаг. Египет нь арабын орнуудын дотор хүн амын хэт өсөлтийн асуудалтай тулгараад байгаа цорын ганц орон юм. Хүн амын 93% нь ислам, 7% нь христийн шашинтан.

1952 онд өөрсдийгөө “чөлөөт офицеруудын нийгэмлэг” гэж нэрлэсэн цэргийнхэн эзэн хаан Фарукуыг хаан ширээнээс буулгасан байна. 1956 онд Гамал Абдел Насер Египетийн ерөнхийлөгчөөр сонгогдсон бөгөөд тэрбээр эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг үндэслэгчдийн нэг байлаа.

Египетийн хувьсгал нь гурван гол шинжийг өөртөө агуулсан байв. Нэгдүгээрт, үндэсний тусгаар тогтнолын төлөө, хоёрдугаарт, социалист хувьсгал байв. Насер антикоммунист үзэлтэн зэрэгцээ бас антикапиталист, антиимпериалист үзэлтэн байлаа. Тэрбээр европын, ялангуяа Их Британий ноёрхлыг эрс эсэргүүцдэг байв. Гуравдугаарт, панарабын үзлийг дэмжсэн, арабын нэгдлийн төлөө хувьсгал байлаа. Насер арабын ертөнц хуваагдмал байгаа нөхцөлд империализм, сионизмын эсрэг тэмцэлд ялалт байгуулж чадахгүй гэж үздэг байв.

1956 онд Суэцийн сувгийг улсын болгосон явдал Египетийн эсрэг Израйлийг дайрахад хүргэсэн бөгөөд чухам АНУ Египетийг Израйльд эзлэгдэхээс сэргийлж чаджээ.

Египетийн эдийн засгийг сэргээхэд гадны тусламж чухал хэрэгцээтэй байсан боловч ЗХУ-аас өөр туслах орон тэр үед байсангүй. ЗХУ-ын тусламжтайгаар Асваны даланг барьж дуусгасан ба бас зэр эвсгийн тусламж их хэмжээгээр авчээ.

Нассер өөрийгөө тахин шүтүүлэх бүхий л зүйлийг бий болгож чадсан байна. Олон түмний нүдэн дээр том самбарт зургаа тавьж, хөшөө дурсгал босгож, зурагт хуудас энд тэндгүй наах зэрэг үйл ажиллагааг нассеризм хэмээх нэр томъёонд хамааруулж ойлгодог. Үүнээс хойш нассерын загварын төр Алжир, Ливи, Сири, Иракт бий болсон байлаа.

Нассерыг 1970 онд нас барсны дараа дэд ерөнхийлөгч Анвар аль Садат төрийн тэргүүн болсон байна. Тэрбээр улс орондоо шинэтгэл хийсэн, тухайлбал шинэ нам байгуулахыг зөвшөөрч, хүний эрхийг өргөтгөх тал дээр мэдэгдэхүйц алхамуудыг хийжээ. Садат 1972 онд ЗХУ-ын 15000 зөвлөгчийг нутгаасаа гаргасан нь дэлхий дахиныг шуугиулсан байна. Тэрбээр аль нэг орноос хараат байх нь колончлолын шинэ хэлбэр гэж үзжээ.

1973 онд Израйлийн эсрэг Йом Киппурт гэнэтийн дайралт хийсэн боловч амжилт олсонгүй. Садат үүнтэй холбогдуулж “Арабууд орчин үеийн зэвсгээр тулалдаж чаддагыг, мөн Израйль үл үзэгдэгч биш гэдгийг Египетийн арми нотоллоо” хэмээжээ.

1977 онд Садат Израйлийн Кнессетед үг хэлж шуугиан тарьсан бөгөөд улмаар 1979 онд Камп Давидэд АНУ-ын ерөнхийлөгч Жимми Картерын зуучлалтайгаар Израйльтай энх тайвны гэрээнд гарын үсэг зуржээ. Үүнээс өмнө Египет арабын ертөнцийг тэргүүлдэг орон байсан бол үүний дараа урвагч, дайсан нь болж хувирчээ. Энэ гэрээний ачаар Египет АНУ, барууны орнуудаас асар их хэмжээний цэрэг, эдийн засгийн тусламж авах болсон байна.

Садатыг 1981 онд Йом Киппурын дайны найман жилийн ойн ёслолд зориулсан цэргийн парадын үеэр исламын экстеримистууд хөнөөжээ. Түүнийг дэд ерөнхийлөгч Хосни Мубарак залгамжлан төр барих болсон байна. 1980 онд Садат Мубарацыг Үндэсний ардчилсан намын тэргүүнээр сонгосон нь түүнийг ерөнхийлөгч болоход нь илүү хялбар болгож өгчээ. 1984 онд 1952 оноос хойш анхны олон намын оролцоотой сонгууль болсон бөгөөд ҮАН-ийг суудлын 4/3 авсан байна. Парламентед орох босго өндөр (8%) тул жижиг намууд бараг суудал авч чаддаггүй.

Египетийн ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар сонгогддог, ерөнхий сайд болон сайд нарыг томилдог. Ард түмний асамблей гэсэн парламентын доод танхим нь таван жилийн хугацаагаар сонгогдоно. Дээд танхим болох зөвлөхүүдийн танхим нь мөн адил ард түмнээс сонгогддог. Египетийн үндсэн хуулийг харвал ардчилсан орны бүх шинж бий. Гэвч бодит амьдрал дээр энэ нь огт өөрөөр явж иржээ.

Исламын фундаментализмын өсөлт Египетэд тулгарч буй гол асуудлын нэг юм. Энэ нь хоёр шалтгаантай. Нэгд, Нассер төр шашныг тусгаарлаж, исламын хууль, уламжлалд харш шинэчлэлтүүдийг хийсэн. Хоёрт, арабын гол дайсан Израйльтай энх тайвны гэрээ байгуулсан явдал орно.

Египет эдийн засгийн хувьд хөдөө аж ахуй дээр суурилсан буурай хөгжилтэй орон байсан бөгөөд 1979 оноос хойш баруунтай харилцах харилцаа сайжирсны ачаар жилдээ хэдэн тэрбум долларын зээл тусламж авах болжээ. 2000 он гэхэд эдийн засгийн өсөлт 6%, инфляци буурч 3% хүрсэн байна. Египет эдийн засгийн хувьд хөл дээрээ баттай зогсож чадсан боловч улс төр, нийгмийн хувьд тогтворгүй хэвээр байна.

Саудын Араб

Сауд омгийн тэргүүн Абд ал Азиз Ибн Сауд арабын хойг дахь олон жижиг овог аймгуудыг нэгтгэн Саудын Араб улсыг 1932 онд байгуулжээ. Түүний гэр бүлийнхэн хөрш омогтоо ялагдсаны улмаас Кувейт руу зугтан гарч байв. Сауд 1902 онд өөрийн цөөн тооны дайчдын хамт Риад хотыг гэнэт дайрч эзлэн авсны дараа 30 жилийн турш тэмцсний эцэст 1932 онд улс орноо нэгтгэж чаджээ.

Өнөөдөр Сауд омгийнхон улс орныг удирддаг. Хааны гэр бүл 5000 хунтайж, гүнжээс бүрдэнэ. Тэд бүгд өөрийн албан тушаал, байр суурьтай ба хунтайж, гүнж тус бүрийг 2000 хүн дагалдан үйлчилж байдаг.

Саудын араб бол шинэ болон хуучны онцгой нийлбэр юм. Нийгэм, улс төрийн хувьд исламын уламжлалыг чанд сахидаг боловч мөнгөөр худалдаж авч болох хамгийн орчин үеийн технологийг улс орондоо нэвтрүүлж чаджээ.

Нүүдэлчин омгийн удирдагч Муххамад ибн Сауд Риад хотын ойролцоох тосгонд амьдардаг Абд ал Ваххаби хэмээх шашны алдартай тэргүүнээс ёс суртахууны дэмжлэг хүссэн бөгөөд үүний оронд Ваххабиг дайснуудаас нь хамгаалахаар болжээ. Энэ үеэс Ваххабын хөдөлгөөн үүссэн байна.

Саудын Арабын эрх зүйн тогтолцоо Ваххабигын уламжлал дээр тулгуурладаг. Олон нийтийн ёс суртахууны хяналтын яам нийгэм дэх хүмүүсийн үйл байдлыг байнга хянаж байдаг.

1964 онд хаан ширээнд суусан Файсал (1964-1975) Саудын Арабыг исламын чанд хатуу соёлын хүрээнд шинэчлэж чадсан байна. Тэрбээр охидуудад боловсрол олгохыг зөвшөөрчээ.

Файсалын удирдлагын дор ОПЕК-ын гишүүн орнууд 1973 онд АНУ болон баруун европын орнуудын эсрэг нефтийн хориг тавьсан юм. Улмаар баррель нь 3 долларын үнэтэй байсан нефть 34 доллар болж өссөн байна. Файсалыг 1975 онд хааны гэр бүлийн нэг гишүүн хөнөөжээ.

Саудын араб нефтээс асар их мөнгө олдог бөгөөд төсвийн 3/1 хувь нь батлан хамгаалах зардалд зарцуулагддаг. Саудын Арабын эдийн засгийн өсөлт маш удаан. Учир нь хааны гэр бүл эдийн засагт хатуу хяналт тавьдаг бөгөөд тэд эдийн засгийн эрчимтэй өсөлт нь нийгэмд тогтворгүй байдал үүсгэнэ хэмээн үздэг.

Персийн булангийн дайны дараа улс орны аюулгүй байдлын үүднээс АНУ-ын цэргийн баазыг нутаг дээрээ байрлуулсан нь нийгэмд хүчтэй нөлөөлжээ. Америк цэргүүдийн нөлөөгөөр Саудын Арабын нийгэмд хагарал үүсэх болсон байна. Уламжлалт үзэлтэн ба шинэчлэгчид, эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хооронд зөрчил бий болж эхэлжээ. Гэвч Саудын Арабын нийгэм харьцангуй тогтвортой хэвээр байна. Энэ бүхний үндэс нь улс орны ганц баялаг болсон газрын тос юм.

АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. al Yassini, Ayman. Religion and State in the kingdom Of Saudi Arabia. Boulder, Colo. Westview.1985
2. Bakhsh, Shaul. The reign of the Ayatollahs: Iran and Islamic Revolution. San Bernardino, borgo Press.1991
3. Bill, James and Robert Springborg, Politics in the Middle East. New York, 2000.
4. Felder, David W. Palestinians and Israil. Tallahassee, Wellington,1996
5. Levis, Bernard The Middle East: A Brief History of the Last 2,000 Years, Touchstone Books, 1997
6. Sachar, Howard M. A History of Israel from the Rise of Zionism to Our Time, Alfred A. Knopf, 1998.
7. Tessler, Mark A. A History of the Israeli-Palestinian Conflict (Indiana Series in Arab and Islamic Studies), Indiana Univ Press, 1994
8. С.Л.Агаев. Иран в прошлом и настоящем. М., 1981
9. И.П.Беляев, Е.М.Примаков. Египет: Время президента Насера. Издание второе. М., 1981
10. К.Н.Брутенц. Развивающиеся страны в 70-е годы. М., 1980
11. К.С.Гаджиев. Геополитика. М., 1997
12. Иран. Очерки новейшей истории. М., 1976
13. Г.А.Насер. Проблемы египетской революции. М., 1979
14. Е.М.Примаков. Восток после краха колониальной системы. М., 1982
15. П.А.Цыганков. Теория международных отношений. М., 2005